



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Энхтайваны гудамж 136, Утас: 7012-8801,  
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,  
<http://www.chd.mohs.mn>

2022. 10. 03 № 816  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг  
бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн  
сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан  
маягтын дагуу тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн  
мэргэшлийн эмнэлгүүдээс 2022 оны 9 дүгээр сарын 30-  
ны өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж  
байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 4 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ

 Б.НАРАНТУЯА - 2



142204000569

## Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

/2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар/

### 1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 383 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа ба дийлэнх буюу 90% нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл**

| №  | Үзлэгийн кабинетын нэр               | Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо |                |
|----|--------------------------------------|-------------------------------------------------------|----------------|
|    |                                      | 4-6 хоног                                             | 7-с дээш хоног |
| 1  | Эмэгтэйчүүдийн мэс засал             | 4                                                     | 74             |
| 2  | Толгой, хүзүүний мэс засал           | 0                                                     | 50             |
| 3  | Хими                                 | -                                                     | 50             |
| 4  | Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал | 2                                                     | 47             |
| 5  | Ангиографи                           | -                                                     | 24             |
| 6  | Ерөнхий мэс засал                    | 28                                                    | 22             |
| 7  | Хөхний төв                           | 1                                                     | 20             |
| 8  | Зүрх судас                           | 2                                                     | 19             |
| 9  | Гепатологи                           | 1                                                     | 19             |
| 10 | Туяа                                 | -                                                     | 10             |
| 11 | Цээжний хөндийн мэс засал            |                                                       | 6              |
| 12 | Ерөнхий хавдар судлал                | -                                                     | 2              |
| 13 | Сэргээн засах                        | 1                                                     | 1              |
|    | <b>Нийт</b>                          | <b>39</b>                                             | <b>344</b>     |

Эмэгтэйчүүдийн мэс заслын амбулаториор 74, Толгой, хүзүүний мэс засал болон Химийн үзлэгийн кабинетад тус бүр 50, Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын үзлэгт 47 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 2-с дээш хоног нийт 97 үйлчлүүлэгч хүлээж байгаа ба КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 48, ходоод дурандуулахаар 22 үйлчлүүлэгч, зүрний бичлэг хийлгэхээр 16 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хоногоор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарч байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Нийт 594 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байна /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл**

| № | Тасгийн нэр | Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо |            |             |      |
|---|-------------|----------------------------------|------------|-------------|------|
|   |             | 3-6 хоног                        | 7-14 хоног | 15-30 хоног | Нийт |
| 1 | Өдрийн хими | 19                               | 141        | 146         | 306  |
| 2 | Хими        | 10                               | 75         | 105         | 190  |
| 3 | Ангиографи  | 3                                | 9          | 18          | 30   |

|    |                                      |           |            |            |            |
|----|--------------------------------------|-----------|------------|------------|------------|
| 4  | Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал |           | 4          | 18         | 22         |
| 5  | Хөнгөвчлөх                           | 1         | 7          | 11         | 19         |
| 6  | Эмэгтэйчүүдийн мэс засал             |           | 4          | 3          | 7          |
| 7  | Ерөнхий мэс засал                    |           |            | 5          | 5          |
| 8  | Хөхний төв                           |           | 2          | 1          | 3          |
| 9  | Дуран                                |           | 1          | 3          | 4          |
| 10 | Туяа                                 |           | 2          | 2          | 4          |
| 11 | Цээжний хөндийн мэс засал            |           | 2          | 1          | 3          |
| 12 | Толгой, хүзүүний мэс засал           |           | 1          |            | 1          |
|    | <b>Нийт</b>                          | <b>33</b> | <b>248</b> | <b>313</b> | <b>594</b> |

Тус эмнэлэгт өдрийн хими эмчилгээ хийлгэхээр нийт 306 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж буй үзүүлэлттэй байгаа боловч хавдартай үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлотт хими эмчилгээ хийдэг нь хүлээгдэлтэй харагдахад нөлөөлдөг болно. Хими эмчилгээний тасагт хэвтэхээр 190 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн 95% нь 7-с дээш хоног ор хүлээж байна. Элэг, цөс, нойр булчихайн мэс заслын тасагт эмчлүүлэхээр 22 үйлчлүүлэгч, хөнгөвчлөх тасагт хэвтэхээр 19 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээсээр байгаа нь тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

## 2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ 2022 оны 9 сард харьцангуй хүлээгдэл багатай байлаа. Нийт 19 чиглэлийн үзлэгийн кабинетад үзүүлэхээр 8 хүн 2-с дээш хоног хүлээж байна. Оношилгоо хийлгэхээр зөвхөн 2 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж байгаа билээ. Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 829 үйлчлүүлэгч ор хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй тасгуудын мэдээллийг Хүснэгт 3-д харуулав.

**Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

| № | Тасгийн нэр                             | Хүлээгдлийн хоног | Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо |
|---|-----------------------------------------|-------------------|---------------------------------|
| 1 | Нүдний тасаг                            | 3-6 хоног         | 18                              |
|   |                                         | 7-14 хоног        | 20                              |
|   |                                         | 15-30 хоног       | 53                              |
|   |                                         | 1 сараас дээш     | 270                             |
|   | <b>Нийт</b>                             |                   | <b>361</b>                      |
| 2 | Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг | 3-6 хоног         | 11                              |
|   |                                         | 7-14 хоног        | 20                              |
|   |                                         | 15-30 хоног       | 53                              |
|   |                                         | 1 сараас дээш     | 110                             |
|   | <b>Нийт</b>                             |                   | <b>194</b>                      |
| 3 | Чих, хамар, хоолойн тасаг               | 3-6 хоног         | 11                              |
|   |                                         | 7-14 хоног        | 20                              |
|   |                                         | 15-30 хоног       | 36                              |
|   |                                         | 1 сараас дээш     | 69                              |
|   | <b>Нийт</b>                             |                   | <b>136</b>                      |
| 4 | Мэс заслын тасаг                        | 3-6 хоног         | 12                              |
|   |                                         | 7-14хоног         | 11                              |



|   |                          |               |           |
|---|--------------------------|---------------|-----------|
| 5 |                          | 15-30 хоног   | 20        |
|   |                          | 1 сараас дээш | 13        |
|   | <b>Нийт</b>              |               | <b>56</b> |
|   | Бөөрний мэс заслын тасаг | 3-6 хоног     | 18        |
|   |                          | 7-14хоног     | 24        |
|   |                          | 15-30 хоног   | 12        |
|   | <b>Нийт</b>              |               | <b>54</b> |

Нүдний тасагт хэвтэхээр нийт 361 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн дийлэх буюу 75% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Харин Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэхээр 194 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 110 нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна. Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 136 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн тал хувь нь 1 сараас дээш хоногоор хүлээгдэлтэй байгаа юм.

### 3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын үзлэг орж байна./Хүснэгт 4/.

**Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

| № | Тасгийн нэр                     | Хүлээгдлийн хоног | Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо |
|---|---------------------------------|-------------------|---------------------------------|
| 1 | Хоол боловсруулах эрхтэн судлал | 3 хоног           | 7                               |
|   |                                 | 4-6 хоног         | 12                              |
|   |                                 | 7-с дээш хоног    | 26                              |
|   | <b>Нийт</b>                     |                   | <b>45</b>                       |
| 2 | Мэдрэл судлал                   | 7-с дээш хоног    | <b>21</b>                       |
| 3 | Мэс засал судлал                |                   | <b>13</b>                       |
| 4 | Бөөр судлал                     |                   | <b>11</b>                       |
| 5 | Эмэгтэйчүүд судлал              |                   | <b>4</b>                        |

Мэдрэл судлал, Мэс засал судлал, Бөөр судлал, Эмэгтэйчүүд судлалын үзлэг хийлгэхээр нийт 59 үйлчлүүлэгч 7-с дээш хоногоор хүлээж байна. Эхо оношилгоо хийлгэхээр хамгийн их буюу нийт 28 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 22 нь 15-с дээш хоногоор хүлээгдэлтэй байна. Мөн рентген зураг авахуулахаар 11 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлэгт биохимийн шинжилгээ хийлгэхээр 22 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 11 нь 3-6 хоног, 10 нь 7-14 хоног, 1 үйлчлүүлэгч 15 ба түүнээс дээш хоног хүлээж байна. Бусад шинжилгээн дээр хүлээгдэлгүй. Орны хүлээгдлийн хувьд авч үзвэл, тус эмнэлгийн Чих хамар, хоолойн тасаг хамгийн их хүлээгдэлтэй байна. Уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 86 үйлчлүүлэгч ор хүлээж байна./Хүснэгт 5/.

**Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

| № | Тасгийн нэр               | Хүлээгдлийн хоног | Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо |
|---|---------------------------|-------------------|---------------------------------|
| 1 | Чих, хамар, хоолой судлал | 3-6 хоног         | 8                               |
|   |                           | 7-14 хоног        | 16                              |

|   |                                            |               |           |
|---|--------------------------------------------|---------------|-----------|
|   |                                            | 15-30 хоног   | 32        |
|   |                                            | 1 сараас дээш | 30        |
|   | <b>Нийт</b>                                |               | <b>86</b> |
| 2 | Мэс засал судлал                           | 3-6 хоног     | 23        |
|   |                                            | 7-14 хоног    | 42        |
|   | <b>Нийт</b>                                |               | <b>65</b> |
| 3 | Хоол боловсруулах эрхтэн судлал            | 3-6 хоног     | 19        |
|   |                                            | 7-14 хоног    | 20        |
|   |                                            | 15-30 хоног   | 17        |
|   | <b>Нийт</b>                                |               | <b>56</b> |
| 4 | Уламжлалт анагаах ухааны эмчилгээний тасаг | 15-30 хоног   | <b>51</b> |
| 5 | Эмэгтэйчүүд судлалын тасаг                 | 3-6 хоног     | 10        |
|   |                                            | 7-14 хоног    | 12        |
|   | <b>Нийт</b>                                |               | <b>22</b> |
| 6 | Нүдний тасаг                               | 3-6 хоног     | 10        |
|   |                                            | 7-14 хоног    | 10        |
|   | <b>Нийт</b>                                |               | <b>20</b> |

Мэс засал хийлгэхээр 65 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн талаас илүү хувь буюу 42 үйлчлүүлэгч нь 7-14 хоног, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 56 үйлчлүүлэгч, Уламжлалт анагаах ухааны эмчилгээг эмнэлэгт хэвтэж хийлгэхээр 51 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус хүлээж байна.

#### 4. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлэг нь тусламж, үйлчилгээний хүлээгдэл багатай ажиллаж байна. 2022 оны 9 сарын 29-ны өдрийн байдлаар амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар 16 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Хэвтүүлэн эмчлэх орны хүлээгдэлгүй боловч MRI шинжилгээ хийлгэхээр 99 үйлчлүүлэгч, КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 18 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

- Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвүүд нь хүлээгдэлгүй ажиллаж байна.
- Улсын гуравдугаар төв эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Амаржих газрууд болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.